



МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

**МОНГОЛ ОРОН:
АРХЕОЛОГИЙН БАЯН
ГАЛЕРЕЙ**

Танин мэдэхүйн цуврал-5

Улаанбаатар хот
2015 он

Д.Цэвээндорж, Я.Цэрэндагва

**МОНГОЛ ОРОН: АРХЕОЛОГИЙН
БАЯН ГАЛЕРЕЙ**

Улаанбаатар
2015

АГУУЛГА

Өмнөх үг	3
Доод палеолитын дурсгалууд	6
Дунд палеолитын дурсгалууд	8
Дээд палеолитын дурсгалууд.....	8
Палеолитын үеийн урлагийн дурсгал	9
Мезолитын үеийн дурсгалууд.....	11
Неолитийн үеийн дурсгалууд	11
Хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үе.....	14
Археологийн дурсгалууд.....	15
Хүннүгийн археологийн дурсгалууд.....	27
Түрэгийн археологийн дурсгалууд.....	35
Уйгурын археологийн дурсгалууд	40
Хятаны археологийн дурсгалууд.....	43
Монголын үеийн археологийн дурсгалууд	45

ӨМНӨХ ҮГ

Монгол орон бол археологийн дурсгалаар нэн баялаг нутгийн нэг юм. Чулуун зэвсгийн бууц суурин дархны газраас авахуулаад хадны зураг, хөшөө чулуу, булш хиргисүүр, хот балгадын үлдэгдэл манай орны дөрвөн зүг найман зовхист байдаг. Манайд ирсэн гадаадын судлаачид, эрдэмтэд “археологийн дурсгалын биет галерей” хэмээн дуу алдан шагширцгаадаг дээрхтэй холбоотой.

Монгол оронд археологийн судалгааг системтэй явуулж эхэлсэнээс хойш 80 орчим жил өнгөрөхөд манай археологчид дангаараа болон гадаадын эрдэмтэн, судлаачидтай хамтарсан судалгаа хийсний үр дүнд чулуун зэвсгийн үеийн бууц, суурин, дархны газар, хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үе, Монгол орны нутаг дэвсгэрт оршин тогтнож байсан эртний улсуудын үе болон дундад зууны үеийн монголчууд, Монголын эзэнт гүрний үеийн булш, хиргисүүр, хөшөө, хот суурин, бичээс, хадны зураг зэрэг олон мянган дурсгалыг илрүүлэн олж эртний түүхийн сан хөмрөгийг баяжуулсан байна.

1950-60-аад оны үед Х.Пэрлээ, Ц.Доржсүрэн, Н.Сэр-оджав, Д.Наваан, Д.Дорж нарын үндэсний археологчид бэлтгэгдэн гарч Монгол орны бичигдээгүй түүхийн нууцыг тайлах ажлыг идэвхийлэн явуулах болсон юм. 1960 онд Монголын хуучин чулуун зэвсгийн үед холбогдох анхны соёлт давхарга бүхий дурсгал болох Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын амны сууринг малтан судлах ажлыг хийсэн нь Монгол нутагт хүн амьдарч байсан цаг хугацааг анх удаа бодит олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан тогтоосон явдал байлаа. Одоогийн байдлаар манай орны нутгаас 1000 гаруй чулуун зэвсгийн үеийн бууц суурин дархны газар илрүүлэн олж хэдэн арван мянган чулуун зэвсгийн зүйлсийг цуглуулан эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ. 2006 онд Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Салхитаас нэн эртний хүний гавлын яс олдсон нь Монгол нутгаас биетээр олдсон анхны олдвор гэдгээрээ түүхэн болоод эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой юм.

Монголын хүрэл ба төмрийн түрүү үед холбогдох Чандмань уулын булш, Пазырыкийн булш зэрэг томоохон дурсгалуудыг илрүүлэн олж малтан судалсны үр дүнд тухайн үеийн аж ахуй, нийгмийн байгууламж, оюуны соёлыг хөгжлийг харуулах олон зуун олдвор хэрэглэгдэхүүнийг олж цуглуулсан байна.

Монгол нутаг дахь буган хөшөөний дийлэнхийг бүртгэн баримтжуулсан бөгөөд одоогийн байдлаар 650 гаруй буган хөшөө манай орны нутаг дэвсгэрт байгаа нь тогтоогджээ.

Монголын анхны төрт улс хүннүгийн археологийн судалгааг манай археологчид олон жилийн турш хийж ихээхэн үр дүнд хүрээд байна. Өнөөгийн байдлаар Хүннүгийн үндсэн нутаг болох Монгол улсын нутаг дэвсгэр болон ОХУ-ын Буриадын Бүгд найрамдах улсын Өвөр Байгал, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орон, Шинжаан Уйгарын өөртөө засах орон, Ганьсу, Хөхнуур мужийн нутгаас нийт 7 мянга гаруй булш олдсоны 5000 орчим нь Монгол улсын нутагт байгааг олж тогтоогоод байна. Мөн 20 орчим хот суурины дурсгал илэрсэний дийлэнх нь манай улсын нутагт бий. Хүннүгийн язгууртны хаад, язгууртны 7 оршуулгын газрыг

илрүүлэн Ноён уул, Дуурлиг нарс, Гол мод, Тахилтын хотгорын булшийг малтан судлах ажлыг сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд хийж олон гайхамшигтай олдвор хэрэглэгдэхүүн олж илрүүлээд байна. Эдгээр олдвор болон судалгаа нь Хүннү гүрний төв өнөөгийн Монгол улсад байсныг гэрчлэх хөдлөшгүй баримт болдог.

Монгол нутагт оршин байсан эртний улсуудын археологийн судалгаанд Билгэ хааны онгоны малтлага онцгой ач холбогдолтой болсон юм. Малтлага судалгааны явцад эдийн соёлын гайхамшигт олдворууд болох 1800 гаруй найман дэлбээт цэцэг хэлбэрт мөнгөн товруу, мөнгөөр үйлдсэн хос буга, алт мөнгөн товруу болон тахилын жижиг сав суулга, үнэт чулуун шигтгээ бүхий алтан титэм зэрэг олдворууд олсон билээ.

Монгол гүрний үеийн үеийн археологийн судалгаанд хот суурин, булш бунхан, хүн чулуу, бичиг үсгийн дурсгалын судалгаа онцгой байр эзэлдэг. Сүүлийн жилүүдэд дундад зууны монголчуудын түүхэнд холбогдох олон арван эд өлгийг зүйлс олдсны дотор Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Таван толгойд хийсэн малтлагаас эвхдэг сандал, малгайн оройны алтан дог ба малгайн нүүрний хэсгийн сийлбэртэй чимэглэл, үсэг бичигтэй ясан тамга, модон хөгжмийн зэмсэг зэрэг урьд өмнө олдож байгаагүй ховор нандин зүйлс байна.

Монгол орон бол археологийн гайхамшигт дурсгалаар нэн баялаг голомт нутаг бөгөөд энэхүү өвөө хайрлан хамгаалж, түгээн сурталчилж, хойч үедээ унаган байдлаар нь өвлүүлэн үлдээх нь бид бүхний үүрэг юм.

ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕ



ДООД ПАЛЕОЛИТЫН ДУРСГАЛУУД

Монгол орны палеолитын үеийн хамгийн эртний үед холбогдох олдворууд бүхий бууц, суурин, дархны газрууд Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын Нарийн гол (17-р суурин), Баянлиг сумын Цагаан агуй, Хатансуудал, Шинэжинст сумын нутаг Эхийн гол, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын төвийн ойролцоо (1-р дурсгалт газар), Олон нуур (2-р суурин), Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Өвөрхангай аймгийн Гучин ус (Гучин ус-4), Ховд аймгийн Манхан сум (4-р суурин), Хойт Цэнхэрийн гол (2-р суурин), Алтай сумын Баралгийн гол (1, 5-р суурин), Үенчийн голын сав (1, 4, 6-р суурин), Дундговь аймгийн Гурвансайхан сумын Ярх уул, Хулд сумын төвийн дэргэд, Дэлгэрцогт сумын Ёроол говь, Дорноговь аймгийн Сайншандын орчим зэрэг газраас олноор байдаг. Дээрхи бууц суурин дархны газруудаас хайрга, зануу, болоржин болон хасын хольцтой шар, хар, цайвар цахиурлаг чулуунаас цуулсан залтас, гурван талт хажуугийн цуулдас, ялтсан хянгар, нэг чулууг нөгөөгөөр цохиж залтас авч байсан үлдэц чулуу, голын хайрган чулуут хөндлөн хагалж хийсэн чоппер (хугадас) зэвсэг, гурвалжин хэлбэрийн гилбэр мэс, хоёр талаас нь зассан үзүүр мэс зэрэг тэр үеийн хүний ахуй амьдралдаа өдөр тутам хэрэглэж байсан чулуун багаж зэвсэг олдсон байна.

Доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь чоппер (хугадас), гилбэр мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг зэвсэг болгон ашиглаж байжээ.



Зураг 1. Хуучин чулуун зэвсгийн үеийн томоохон дурсгалт газрууд



ДУНД ПАЛЕОЛИТЫН ДУРСГАЛУУД

Дунд палеолитын үеийн хүний хөдөлмөрийн багаж зэвсэг бүхий бууц суурин Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оцонмааньт, Булган сумын Цахиуртын хөндий, Гурвансайхан, Баянхонгор аймгийн Богд сумын Орог нуурын хөндий (Орог нуур 1,2), Шинэжинст сумын Босго, Өвөрхангай аймгийн Богд сумын Арц Богд уул, Хархорины орчим Орхон голын сав (Орхон 1; 7 доод давхарга), Мойлтын амны зүүн дэнж, Ховд аймгийн Баралгийн гол (Баралгийн гол 1), Хойт Цэнхэрийн гол (Хойт Цэнхэр 2), Олон нуур (Олон нуур 1), Өмнөговь аймгийн Баяндалай сумын нутаг, Говь-Алтай аймгийн Сүүжийн хөндий, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын Цагаан түнгэ зэрэг олон газраас олдсон байна.

Оцон мааньтаас дугуй ба тэгш өнцөгт, шовхдуу маягийн үлдэцүүд, өргөн урт ялтас, хянгар зэрэг леваллугийн аргаар хийсэн эдлэлээс гадна мустьегийн гурван талт үлдэцүүд Олон нуур, Баралгийн голоос леваллуа-мустьен арга техникээр хийгдсэн эдлэлүүд Орог нуур 1, Орог нуур 2-ын суурингаас уртавтар ялтас цуулж авсан нэг ба хоёр талбайт үлдэц, өргөн богиновтор залтас цуулж авсан леваллуагийн үлдэц, леваллуагийн залтас, ялтас, үзүүр мэс, Орхоны хөндийн суурингаас шүдлэг иртэй зэвсэг, хүнхэр ирт хянгар, бусад төрлийн хянгар зэвсгүүд олон тоогоор олдсон байна.

Мустьегийн үед чулуун зэвсгээс гадна ан агнах болон түүнтэй холбогдсон өдөр тутмын үйл ажиллагаанд том амьтдын хавирга, эрүү, чөмөг, далны ясыг бага сага засаж зэвсэг хийх, урт модны үзүүрийг галд түлж хатууруулан модон жад хийж оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглах явдал багагүй үүрэгтэй байжээ. 2006 онд Хэнтий аймгийн Норовлин сумын нутгаас олдсон “*Mongolanthropus*” хэмээх нэрээр дэлхийн шинжлэх ухаанд нэрлэгдээд байгаа эртний хүний гавлын ясны үлдэгдэл нь Монголын нэн эртний түүхийн судалгаанд чухал олдвор болсон юм.



ДЭЭД ПАЛЕОЛИТЫН ДУРСГАЛУУД

Палеолитын дараагийн үе болох дээд палеолит нь мөстлөгийн эцсийн шатанд холбогддог бөгөөд ойролцоогоор одоогоос 40 000-35 000 жилийн тэртээ эхэлж 12-10 мянган жилийн өмнөх үе хүртэл үргэлжилжээ.

Дээд палеолитод холбогдох анчдын бууц суурин манай улсын бараг бүх аймгийн нутгаас олддог. Тэдгээрээс тодорхой хэмжээгээр судлагдсан суурингуудын тоонд Архангай аймгийн Ихтамир сумын нутагт Хойд Тамирын голын сав, Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын нутаг Чихэн агуйн доод давхарга, Цагаан агуйн дээд давхарга, Түйн голын сав, Байдраг голын сав, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Төлбөрийн голын сав, Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Мойлтын ам, Богд сумын нутаг Арц богдын Мухар булаг, Их булаг, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Сагсай голын сав, Ховд сумын нутаг Ховд голын сав,

Баяннуур, Улаанхус, Ховд аймгийн Манхан сумын 5-р суурин, Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Рашаан хад зэрэг дурсгалууд багтана.

Мойлтын амны сууринг малтахад үлдэц, хугадас маягийн цавчих зэвсэг,



хянгар, хусуур, цоолтуур, хутга, үзүүр мэс, ирлэж зассан ба засаагүй хэдэн зуун чулуун эдлэл гарсан байна. Энэ суурин монгол орны хувьд анх удаа олдсон соёлт давхарга бүхий суурин юм. Нийт 5 соёлт давхарга илэрч олдсон бөгөөд энэ нь энд дээд палеолитын эхэн үеэс мезолитын үеийг хүртэл эртний хүн тасралтгүй оршин амьдарч ирсний баталгаа болж өгч байгаагаарай ач холбогдолтой юм.

Дээд палеолитын хүн олон төрлийн зэвсэг хийж эзэмших болсон нь түүний амь зуух үндсэн сурвалж болох ан агнуурыг улам боловсронгуй болгож тодорхой хэмжээний газраас хэрэгцээний хэрээр агнуурын олз омог олж, нэг газарт удаан хугацаагаар оршин суух бололцоотой болжээ.

Нөгөө талаар манай орны дээд палеолитын чулуун зэвсгүүдтэй адил төстэй эдлэлүүд Умард Азийн мөн үеийн дурсгалуудад элбэг бөгөөд хийсэн аргын уламжлалын хувьд ижилсэж байгаа нь Монголын палеолитын үеийн анчдын зарим хэсэг их гол мөрний хөндий дамжин умард зүг нүүдэллэн очиж суурьшиж байсны баримт юм.

Дээд палеолитын үеийн хүн агуй хонгилог оромж болгон ашиглаж байснаас гадна нөмөр дулаан газарт урц маягийн сууц барьж суух болсон бөгөөд тэдгээр сууцны гал голомтын үлдэгдлүүд археологийн малтлагаар олдож байна.

ПАЛЕОЛИТЫН ҮЕИЙН УРЛАГИЙН ДУРСГАЛ

Палеолитын үеийн хүмүүсийн оюуны соёл, ертөнцийг үзэх үзлийг тодорхойлон судлахад тэдний үлдээсэн урлагийн дурсгалууд эн тэргүүн чухал хэрэглэгдэхүүн болдог.

Дээд палеолитын үеэс эртний хүмүүс өөрсдийн орогнон амьдарч байсан агуй хонгилынхоо хана болон хаданд араатан амьтдыг зурж дүрслэх болжээ. Эртний анчид өдөр тутмын амьдралтай нь салшгүй холбоотой, амь зуулгынх нь амин сүнс болж байсан араатан амьтдын зан ааш, хөдөлгөөн бүрийг ихэд гярхай ажиглан мэддэг байсан нь хад чулуунаа тэдгээрийг бодитой, ихэд уран чадамгай дүрсэлснээс харж болно. Хаднаа зураг зурахдаа палеолитын үеийн хүмүүс байгал дээр элбэг тааралддаг шороон будаг буюу улаан хүрэн зосыг, агнасан араатан амьтдынхаа

өөхтэй хольж зураг зурдаг байсан бололтой. Эртний зураачдын үлдээсэн зургуудаас харахад одос үхэр, арслан зааны дүрс голлох байр эзэлдэг байна.

Манай орны хувьд хадны зосон зураг Ховд аймгийн Манхан сумын нутаг Хойт Цэнхэрийн агуйд байдаг. Хойт Цэнхэрийн агуйн цайвар өнгийн хананд ан амьтан, мод зэргийг дүрслэхдээ нэг хэсэг зургийг өтгөн улаан хүрэндүү, нөгөө хэсгийг арай



цайвар ягаан туяатай, улаан шаргал өнгийн зосон будгаар зуржээ. Агуйн мухрын тааз болон хананд олон тооны ан амьтан, тэмдэг сэлтийг бие бие дээгүүр нь давхардуулан зуржээ. Энд тайван зогсож байгаа буга, данхар том эвэртэй одос үхэр, арслан заан, тэмээн хяруул, аргаль, янгир зэргийг дүрсэлсэн байна. Үүнээс гадна 8 м өргөн, 10 м урттай өөр нэгэн хонгилын хананд хоёр бөхтэй тэмээ, мод, олон тооны тэмдэг дүрс зэргийг зурсан байна.

Палеолитын үед хамаарах хадны сийлмэл зургууд Ховд аймгийн Манхан сумын Ишгэн толгой, Буянт сумын Чандмань хар үзүүр, Увс аймгийн Сагил сумын Хад үзүүр, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Бага ойгор, Цагаан салаа, Цэнгэл сумын нутаг Арал толгой зэрэг газраас олдсон бөгөөд бүгдийг бодит байдлаар дүрсэлжээ.



МЕЗОЛИТЫН ҮЕИЙН ДУРСГАЛУУД

Хуучин чулуун зэвсгийн дараагийн үеийг дундад чулуун зэвсгийн үе буюу мезолит (12.000-7.000 жил) гэж нэрлэдэг ба палеолитоос неолит буюу шинэ чулуун зэвсгийн үед шилжих шилжилтийн үе болно.


Мезолитын үе нь бүхий л шинж чанараараа шилжилтийн гэдэг нь харагддаг.



Мөстлөгө дуусч, цаг агаар дулаарч, ургамал, амьтны аймагт ч өөрчлөлт орж, ингэснээрээ хүмүүсийн амьдрал ахуйд ч тодорхой ахиц дэвшил гарсан байна. Мезолитын үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдаж, хүн төрлөхтний зэр зэвсгийн үйлдвэрлэлийн түүхэнд онцгой чухал үүрэг гүйцэтгэсэн, модны уян хатан шинжийг ашиглаж хийсэн холын тусгалтай зэвсэг болох

нум сумыг анх зохион бүтээж бий болгожээ.

Мезолитын үеийн чулуун зэвсгийн дурсгалт газрууд Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Дорнод аймгийн Халхгол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаанхад (II-III үе), Баян-Овоо сумын нутаг Гүрмийн нуур, Батхаан уул, Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун хайрхан, Зүүн хайрхан уул зэрэг олон газраас илэрч олдоод байна. Харин мезолитын үеийн хадны зургийн дурсгалт газар Увс аймгийн Сагил сумын нутаг Можоогийн хад, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуу, Хэнтий аймгийн Батширээт сумын нутаг Рашаан хаданд бий.



НЕОЛИТИЙН ҮЕИЙН ДУРСГАЛУУД

Ойролцоогоор 8.000 жилийн тэртээгээс төмөрлөг зэвсэгт шилжих хүртэлх үеийг хамарсан энэ үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй буюу газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.



Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл, зориулалтын эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Чулуун эдлэл хийхэд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, хөрөөдөж ховил гаргах,



өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино. Неолитын үед шавар ваар савыг анх хийж эхэлсэн байна. Неолитын үеийн багаж зэвсэг, ваар сав бүхий чулуун зэвсгийн бууц суурин Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Зуух, Зоог, Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Сагсайн гол, Дорнод аймгийн Чойбалсан хотын ойролцоо, Хэрлэн сумын нутаг Тогоот нуур, Булган сумын нутаг Баруун Өлзийт, Зүүн Өлзийт, Мөнх толгой, Хэрлэнгийн 9-р суурин, Баянтүмэн сумын нутаг Овоот, Халхгол сумын нутаг Хүйтэн булаг, Тамсагбулаг, Халх гол, Мэлхийт нуур, Дашбалбар сумын нутаг Ямаат нуур, Матад сумын Лам чулууны таг, Сүхбаатар аймгийн Онгон сумын нутаг Онгон элс, Баруун элс, Таван толгой, Дариганга сумын Овоон элс, Ар булаг, Дагшин булаг, Хонгор сумын Гүнбулаг, Наран сумын Эхэн усны баруун эрэг, Мөнхаан сумын Устай бургастай, Ваарт элс, Баяндэлгэр сумын Их Мандал хайрхан, Баруун-Урт сумын



нутаг Долир манхан, Их айлын Манхан, Дорноговь аймгийн Хатанбулаг сумын нутаг Сулыт хээр овоо, Сайхандулаан сумын нутаг Чандмань хар уул, Сэглэгтийн улаан зээрд, Цагдуулын өртөө, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын нутаг Улаанбургас, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын нутаг Хөшигийн үзүүр, Хэнтий аймгийн Биндэр сумын нутаг Зүүн Хужирт, Биндэр уул, Баянмөнх сумын нутаг Баянцогт овоо, Баян-Адарга сумын нутаг Элгэн хүзүүвч,

Цэнхэрмандал сумын Устын дэнж, Батширээт сумын Өглөгчийн гол, Рашаан хад Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Баянзаг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Билүүт зэрэг газраас олдоод байна.

Неолитын үеийн хадны зургийн дурсгал болох улаан зосон зургууд Өвөрхангай аймгийн Дэлгэрэх сумын Цоорхойн агуй, Уянга сумын Шурангийн улаан хад, Тарагт сумын Баглуур хад, Төв аймгийн Зуунмод, Дундговь аймгийн нутаг Гэрчулуу, Архангай аймгийн Жаргалант сумын Улиастын гол, Дулааны үзүүр, Төв аймгийн Баян-Өнжүүл сумын Зорголхайрхан, Хэнтий аймгийн Биндэр сумын Бичигхад, Баянхонгор аймгийн Баянлиг сумын Цагаан агуй, Баян-Өндөр сумын Саальтын агуй, Цагаанмагнайн агуйгаас тус тус олдоод байна.



ХҮРЭЛ БА ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕ

ХҮРЭЛ БА ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Монгол орны хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн археологийн дурсгалуудад булш, хиргисүүр, буган хөшөө, хадны зураг зэргийг холбогдуулдан авч үздэг. Булшууд нь маш олон янз хэлбэртэй байх бөгөөд гаднах хэлбэр төрх, олдсон газрынхаа нэр зэргээр нэрлэгддэгийн дээр зарим булшийг тусгай соёлд хамаатуулан авч үзэн нэрлэх нь ч бий. Тухайлбал, дөрвөлжин булшны соёл, шоргоолжин булшны соёл, Чандманий соёл, Пазырыкийн соёл, Мөнххайрханы соёл г.м.

Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Энэхүү булшийг үлдээгсэдийг бүхэл бүтэн нэгдмэл соёлд хамруулан авч үздэг.

Дөрвөлжин булшийг гаднах зохион байгуулалтын хувьд үндсэн 4 хэлбэрт хуваадаг байна. Үүнд:

1. Дөрвөн буландаа өндөр чулуутай, дөрвөн өнцөг хүрээтэй;
2. Дөрвөн талын хүрээ нь намхавтар хавтгай чулуун дараас бүхий;
3. Онцгой өндөр ханатай;
4. Дөрвөн тал нь дотогшоо хотгар ханатай;

Дөрвөлжин булшны зохион байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн



нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг. Хүнийхээ

толгойг ихэвчлэн нар мандах зүг буюу зүүн зүг харуулан цэх байдалтайгаар дээш харуулан 50-150 см-ийн гүнд оршуулж, цахиур чулуун зэвсгийн зүйл, хүрэл хутга, сумны зэв, хүрэл товч, товруу, морь малын дүрстэй хүрэл чимэг, хагас товгор хүрэл чимгүүд, модоор сийлсэн шувууны толгой, үсний алтан сүлбээр, шавар ваар, зэс, хүрэл хайлуулдаг чулуун шанага, хүрэл дуулга зэрэг олон төрлийн эд өлгийн зүйлс, малын толгой, чөмөг, дал зэргийг дагалдуулан тавьсан байдаг. Гол төлөв хүнийхээ толгой дор дэр болгон хавтгай чулуу тавьдаг байжээ.

Сүүлийн жилүүдэд явуулсан археологийн малтлагаас гарсан, хүрэл зэвсгийн үеийн зэр зэвсэг, байлдааны хэрэгсэлийн талаар цоо шинэ мэдээлэл өгсөн олдворуудын тоонд Булган аймгийн Хутаг-



Өндөр сумын нутаг Эгийн голын 2 дөрвөлжин булшийг малтахад олдсон хоёр хүрэл дуулга зүй ёсоор багтдаг.

Монгол орны хүрлийн үеийн гоёл чимэглэлийн зүйлсийн олдвор дотроос хамгийн сонин содон олдвор бол Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш ууланд малтсан булшнаас гарсан аргалийн толгойн хэлбэртэй хоёр алтан сүлбээр юм.

Сүлбээрийн их биеийн дээд хэсгийг хэдрэгний ир мэт биржгэрээр, хоёр хажууг шаталсан биржгэрээр, тус тус чимсэний гадна аргалийн нүд чих сүлбээрийн нууханд ногоон оюу шигтгээ суулгаж гоёл чимэглэлийн өнгө хорших аргыг хэрэглэсэн байна.



Хиргисүүр. Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Манай орны нутаг дэвсгэрт хиргисүүр маш өргөн хэмжээгээр тархсан байдаг бөгөөд харин бусад булшуудыг бодвол харьцангуй бага малтан судлагдсан ажээ.

Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд 30 орчим төрөлд хуваагдаж байдаг.



Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед холбогдуулан авч үздэг.

Буган хөшөө. Буган хөшөө бол Монгол болон Төв Азийн нутаг дэвсгэр дээр хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үед оршин сууж байсан овог аймгийн түүх соёлын гайхамшигтай дурсгалын нэг билээ.


Гонзгой урт чулуут засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бутыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулуут буган хөшөө хэмээн нэрлэдэг.

Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг ба мөн бутын дүрсний оронд буюу завсар зайд адуу ирвэс, янгир, зээр зэрэг амьтад хааяа дүрсэлсэн байдаг.

Евразийн өндөрлөгөөс 800 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлснээс 650 гаруй нь Монгол улсын нутгаас олджээ.

Буган хөшөөг хэлбэр төрхийн хувьд үндсэн гурван төрөлд хуваан авч үздэг. Үүнд:

1. Монгол-Өвөрбайгалын бутын загварчилсан дүрс бүхий буган хөшөө
2. Саян-Алтайн амьтны “бодит” дүрст буган хөшөө
3. Ази-Европын амьтны дүрсгүй буган хөшөө хэмээн ангилдаг байна.



Б у г а н х ө ш ө ө н и й г у р в а н х э л б э р т ө р х



Б а я н ц а г а а н ы х ө н д и й н б у г а н х ө ш ө ө д , А р х а н г а й ,

Буган хөшөөний нэг талд бугын оронд адууг дүрсэлсэн хөшөө Архангай аймгийн нутаг Алтансандлаас олдсон. Буган чулуун хөшөөний бүснээс зүүж хутга, билүү, чинжал хутга, жад, нум, сум, саадаг, байлдааны зээтүү, сүх, бамбай зэрэг зэр зэвсгийн зүйлсийг дүрслэх бөгөөд тэдний заримыг гоёж чимэн дээр нь хээ зураас, дугуй, дөрвөлжин, хонхортой цохиж гаргасан байдаг.



У у ш г и й н ө в р и й н б у г а н х ө ш ө ө д

Хадны зураг. Монгол орны нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн үлдээсэн өөр нэгэн хосгүй дурсгал бол хадны зураг юм.



Энэ үед холбогдох хадны зургийг улаан зосон, сийлмэл хэмээн ангилан авч үздэг. Улаан зосон зургийг өөр өөр үед зурсан бөгөөд дүрс, утга агуулгаараа хорондоо өвөрмөц ялгаатай байдаг тул судлаачид хэдэн төрөл болгон ангилан судалж иржээ. Монгол орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь “Сэлэнгэ”-ийн төрлийн зосон зураг юм.

Энэ төрлийн зосон зураг Улаанбаатар хотын дүүрэг Богдхан уулын Их тэнгэрийн ам, Гачууртын ам, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Гачуурын бичиг, Улаан-уул сумын нутаг Толжийн боом, Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Зэлтэрийн голын Цагаан Оломын гарам, Хүйтний голын бичигт хад, Шарын голын Цагааннуур, Хэнтий аймгийн Дадал сумын Балжийн хавцгай, Булган аймгийн Орхон сумын Баруун могой гол, Орхон гол, Бугат сумын Бичигт хад зэрэг газраас олджээ. Энэ төрлийн зургийн бүхий л талын шинжийг агуулсан хамгийн сонгодог зураг бол Ихтэнгэрийн амны зураг билээ. Хадны зургаас харахад дүрслэлийн төв хэсэгт нь дотроо олон дугуй толбо бүхий дөрвөлжин хашлага болон дугуй хүрээг зурсан

байдаг ба түүний дээд талд далавчаа дэлгэсэн бүргэд шувуу, доогуур болон хажуу талаар нь хөтлөлцсөн хэдэн хүн, зэрэгцээ хоёр замаар адуу хөтлөн явж байгаа хүн зэргийг голчлон дүрсэлсэн байдаг.



“ С э л э н и г н ө ” т ө р л и й н з о с о н з у р г и й н х э с г э э с

Хадны сийлмэл зургийн дурсгал монгол нутгийн хад чулуунд харьцангуй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг. Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зургууд зохиомж, сийлсэн арга барилын хувьд тод ялгагдана. Юуны түрүүнд ямар нэгэн амьтныг дүрслэхдээ загварчилан дүрсэлсэн байх явдал ажиглагддаг. Ан амьтдыг ганц нэгээр нь дүрслэхээс гадна олон сүргээр нь үйл явдлын өрнөл дунд дүрслэх явдал ихэд дэлгэрсэн байна. Мөн ан хийж байгаа анчид, хоорондоо дайтаж байгаа дайчид зэргийг ч олонтоо дүрсэлсэн нь бий. Голчлон дүрслэгдсэн араатан амьтад гэвэл янгир, буга, аргаль угалз, гахай, үхэр, адуу, тэмээ, морь, чоно, нохой юм.

Хүрэл зэвсгийн үеийн сийлмэл зурагт тэргийг дүрслэх явдал түгээмэл байжээ. Архангай аймгийн Чулуут голын сав дагуух хаданд хосморь хөллөсөн тэрэг, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Модтой толгойн хаданд замын хоёр талаар цуварч яваа хэд хэдэн морин тэргийг дүрсэлсэн байдаг. Ийнхүү тэргийг моринд хөллөсөн байдалтайгаар дүрслэхээс гадна дангаар нь дүрслэх явдал ч бас тааралддаг. Манай орны Баянхонгор аймгийн Баянлиг сумын Их Баянуулын Бичигтийн ам, Шинэжинст сумын Цагаанхаалга, Гэцэлийн ус, Сонгинот, Бууцагаан сумын Гурван Мандал, Баян-Өлгий аймгийн Цагаан салаа, Бага Ойгор, Билүүт, Хөлцөөт, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Өвгөнт, Үүдэнт, Хөтөл өтгө, Орхон сумын Орхон гол, Баруун могойн гол, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Дэл уул, Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутаг Молор толгой, Шаахар толгой, Цагаан гол, Архангай аймгийн Чулуут сумын Чулуутын гол, Ховд аймгийн Үенч сумын Ямаан ус, Хэнтий аймгийн Батширээт сумын Үзүүр цохио, Рашаанхад, Өмнөговь аймгийн Ноён сумын Аравжих, Ханбогд сумын Жавхлант хайрхан, Далайн дуулга, Булган сумын Хавцгайт, Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Гучинус сумын Их дөрөлж, Паалуу, Увс аймгийн Сагил сумын Гурвантурга, Хандгайтын гол, Могой, Бужаа, Төмөр цорго, Эхэн хүзүүвч, Өмнөговь сумын Шарбулгын онц зэрэг олон газрын хаднаа хүрэл зэвсгийн үеийн хүмүүс өөрсдийн бүтээлээ мөнхлөн үлдээжээ.



Цагаан Салаа, Бага Ойгорын хадны зургийн




Дэл уул болон Тэвшхуулын хадны зургийн



Шивээт хайрханы хадны зургийн хэсгээс

Чандманий соёл. Монгол оронд төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан хүмүүсийн аж ахуй, соёлын олон талт асуудлыг улируулан тодруулан судлахад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулын булшууд онцгой ач холбогдолтой юм. 1972-1974, 1981 онуудад манай археологчид энд 60 гаруй булшийг малтаж шинжилсэн байна. Чандмань уулын булш гадаад хэлбэр төрх, үхэгсдийг оршуулсан зан үйлээрээ том дөрвөлжин чулуун далантай, чулуун далантай авсгүй, жижиг чулуун австай, дүнзэн бунхантай шороон булш гэсэн үндсэн дөрвөн төрөлд хамаардаг.



Дээрхи булшуудаас чинжаал хутга 10 гаруй, байлдааны хүрэл ба төсөр зээтүү, нум сумны хэсэг, харвуулын сумны хүрэл ба ясан зэв, саадагны хүрэл гох, хүрэл төмөр хутга, хүрэл, ясан шөвөг, олом, хазаар, бүс, тэлээний хүрэл арал, сийлбэртэй бүсний арал, хүрэл шахуурга (бөгж), ясан шахуурга, төмөр гархи, хүрэл, төмөр товруу, хүрэл толь, алтан шармал, хар тугалган ээмэг, буга маралын араан зүүлт, тарваганы соёон зүүлт, цагаан сондор, хөх буюу ногоон өнгийн сондор, оюу зүүлт, алагбөөртэй (нүдтэй) шилэн эрхи, явуу, хүрлээр хийсэн явуу, ясан ба занарлаг чулуулаг (богхед)-аар хийсэн жижиг ялтас, хүрэл товруу бүхий чимэглэл, хүрэл товч, товруу, богийн шагай, хүрлээр хийсэн адуу, тэмээний толгой, шар шувууны толгойн дүрстэй товруу, даруулга, модон сам, шавар, хүрлээр хийсэн сав суулга, модон сав суулганы хэлтэрхий, хүрэл тогоо зэрэг олон төрлийн эд өлгийн зүйлс олджээ.

Чандмань уулын булшнаас 60 гаруй бүтэн шавар сав олдсон бөгөөд тэдний ахуй амьдралд шавар сав суулга чухал хэрэгцээтэй байсны баримт юм.





Чандманийн хүрэл эдлэлүүд

Пазырыкийн соёл. Монгол Алтайтай хил залгаа Орос, Хятад, Казахстаны Алтайд МЭӨ VI-II зуунд холбогдох пазырыкийн соёлын дурсгалууд элбэг тархжээ. “Пазырык” гэдэг үг нь Орос Алтайд байх нэгэн асар том булшны нэр. Монголчилбол “булш” гэсэн үг бөгөөд монголын мончок-тува нар булшийг “бажираг” гэж хэлдэг байна.

Пазырыкчууд бол хагас нүүдлийн мал аж ахуйг эрхлэхийн зэрэгцээ газар тариалан, загас агнуурыг хавсарга хэлбэрээр эрхэлдэг байжээ. Мөн өндөр хөгжсөн гар урлалтай байсныг булшнаас гардаг урлагийн гайхамшигт бүтээлүүд гэрчилдэг. Тэд антропологиин хэв шинжийн хувьд монгол, европ төрхтний холимог бөгөөд жирийн иргэдийн хувьд европоид төрх давамгайлдаг бол язгууртны дунд монголоид төрх давамгайлдаг. Нийгмийн зохион байгуулалтын хувьд нарийн бүтэцтэй давхраажсан болох нь “хаадын булш” ба жирийн иргэдийн булш хэмжээ хэлбэр, дагалдуулсан эд өлгийн зүйлийн хувьд эрс ялгаатай байдгаас тод мэдэгдэнэ.

Анх 2004 онд дээрх төрлийн дурсгалыг Монгол Алтайд илрүүлснээс хойш одоогийн байдлаар 500 гаруйг бүртгэн баримтжуулжээ. Тэдгээрээс 30 гаруйг малтан судлаад байна.



Пазырыкийн оршуу-Өлвийза Сарса Баян


Малтлагаас илэрсэн олдворуудын дотор олон арван модон сийлбэр эдлэл байгаа нь одоогоос 2500 орчим жилийн өмнөх цаг үед холбогдох нэн эртний урлагийн бүтээлүүд юм. Түүнчлэн олон төрлийн их хэмжээний ноосон нэхмэл эдлэл гарсан нь туйлын ховор илэрдэг онцгой ховор олдвор болно.



Бага Түргэний голын пазырык булшны модон чимэглэл

Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Олон гүүрийн голд малтсан булшнаас модон цар, зэвсэг багажийн модон иш бариул, модоор хийсэн гоёл чимэглэлийн зүйл, хүзүүвч, модон гөрөөсний баримал зэрэг бусад модон эд зүйлс,

арьсан эдлэлүүд, арьсан дээл, өмд, эсгий болон арьс хослуулан хийсэн урт түрийтэй гутал зэрэг эд өлгийн олдсон нь судалгааны өндөр ач холбогдолтой олдворт тооцогддог.



О л о н з ү ү р т й з ы ф а ж и н



О л о н г ү ү р и й н г о л ы н б у л ш н ы о р ш у у л г а



О л о н г ү ү р и й н г о л ы н р б ц а ш и н д ж э л р л т а о р а н ө м д

ХҮННҮГИЙН ҮЕ

ХҮННҮГИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Хүннүгийн археологийн дурсгалыг дотор нь булш бунхан, хот суурин, хадны зураг гэж ерөнхийлөн ангилан авч үздэг.

Хүннүгийн булш бунхан. Хүннүгийн үед холбогдох булш бунханыг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд зүйл зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваадаг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсийн хувьд ч ялгагдана.

Язгууртны булш нь хэмжээний хувьд харьцангуй том, дөрвөлжин чулуун өрлөг далантай, үүдэвчтэй байдаг. Үүдэвчийг дөрвөлжин далангийн чанх урд чулууг давхарлан өрж үйлддэг байсан байна. Үүдэвчний голоос эхлэн булш хүртэл хавтгай чулууг босоогоор нь зоож босгосон байдаг. Зарим булшны дотор талд хэд хэдэн эгнээ чулуун хана босгодог байжээ. Нас барсан хүнээ 8 м-ээс доош гүнд хоёр давхар тусгай дүнзэн бунхан доторхи модон авсанд оршуулдаг байжээ. Хүннүгийн язгууртны ийм булш манай орны Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигт, Зурамт, Хужиртын ам, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Архангай аймгийн Хайрхан сумын Гол мод, Өндөр-Улаан сумын Голмод-2, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Борбулаг, Дуурлиг нарс, Улаанбаатар хотын Бэлхийн ам зэрэг газруудад бий.

2000 оноос Хүннүгийн язгууртны булшны судалгаа эрчимжиж Ноён уул, Гол мод, Тахилтын хотгор, Гол мод II, Дуурлиг нарс зэрэг томхон дурсгалт газруудад малтлага судалгаа хийгдсэн байна.




Г о л Ноён-р I б у л ш




Ноён ухуулын нугийн язгууртны булш, зарим олдвор


Хүннү нар Хан улс төдийгүй өрнө, дорны бусад орнуудтай харилцаж байсныг археологийн сүүлийн үеийн судалгаагаар илэрсэн шинэлэг олдворууд гэрчилж байна. Үүнд, Ноён уулын 20-р булшнаас олдсон Эртний Грекийн домгийн бурхдын дүрстэй хөөмөл мөнгөн чимэглэл, эсгий ширдэг дээрх домгийн амьтдын дүрс, Гол модны 20-р булшнаас илэрсэн бэлгэт гөрөөс буюу ганц эвэрт (юникорн)-ийн дүрст худараса, хөмөлд рөгний чимэглэл, өнөөгийн Афганистаны Тиале Тепе хэмээх газраас олдсонтой ижилсэх үрлэн хээгээр чимэглэсэн хатгуур чимэглэл, 2005 онд Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг, Бага газарын чулуун Ихэрийн ам хэмээх газар малтан судалсан хүннүгийн жирийн иргэний булшнаас гарсан хүний дүрс бүхий эдлэл, салаавч дүрстэй чулуун зүүлт (Египетийн бес бурхны хөрөг) зэрэг зүйлс багтана.



Хударга хөмөлд рөгний чимэглэл



Гол модны булшгаас олдсон тэргэний эд ангиууд
тэргийг нэхэн сэргэсэн байдал



Ноён урлѣнулбинаас гарсан ширдэг



Ноён уурьбузйнашир дөрөмийг


Хүннүгийн жирийн иргэдийн булшийг Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт, Үүдэнт, Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгой, Хөвсгөл аймгийн Галт сумын Нүхтийн ам, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаатолгой, Батцэнгэл сумын Худгийн ам, Солби уул, Хөвсгөл аймгийн Их-Уул сумын нутаг Сул толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул зэрэг олон газруудад малтан шинжилжээ.

Жирийн иргэдийн булшинд хүнээ дагалдуулан гол төлөв нум сум, жад, илд, чинжал хутга, эмээл хазаарын тоног хэрэгсэл, чимэг, хувцас хунар, хүрэл сав суулга, үнэт чулуун ба шил сувсан зүүлт, алтан чимэг, хүрэл толь, зэрэг гоёл чимэглэлийн зүйлс, мал, ангийн мах, үр тариа зэргийг тавьдаг байжээ. Тэгэхдээ эд өлгийн зүйл бүрийг утга учиртай тодорхой байранд, хэвшсэн заншлын дагуу хийдэг байсан нь мэдэгддэг.



Х у д г и й н т о л г о й н х ү н н ү г и й н ж и р и й н и р г э д и й н о р





Хүннүгийн жирийн иргэдийн булшнаас олдсон з а

Хүннү булшнаас сумны гурван хянгат, шөрөгт төмөр зэв, навчин хэлбэрийн төмөр зэв, нуманд хүч оруулах бариулын, гичирийн, элэгний ясан наалт олноор олддог нь хүннүчүүд ясан наалт бүхий хүчит нумыг хэрэглэж байсны баталгаа болж өгдөг.

Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бурхан толгойн 26, 28-р булшнаас тод хар өнгийн бэхний толботой бийрний чулуун янтай олдсон нь хүннүчүүд бичиг үсэг хэрэглэж байсныг харуулах чухал олдвор билээ.

Хүннүгийн хөгжмийн зэмсгийн гайхамшигт дурсгал болох ясан хэл хуур Төв аймгийн Алтанбулаг сумын Морин толгойгоос илэрчээ. Энэ хэл хуур нь даруй 2000 гаруй жилийн тэртээд холбогдох ба энэ төрлийн хөгжмийн зэмсгийн одоогоор мэдэгдэж байгаа хамгийн эртнийх ч байж магадгүй юм.

Хүннүгийн хот суурин. Хүннү нар нь нүүдэлчин аймгуудын дотроос анхны хот суурин газруудыг байгуулж байсан ард түмэн билээ. Археологийн судалгаагаар хүннү нар нь мал аж ахуй голлон эрхлэхийн зэрэгцээ хот суурин байгуулж байсны бодит нотолгоо болох олон хот суурины үлдэгдлийг илрүүлэн олж судалжээ.

1952 оноос Монголын ууган археологич, эрдэмтэн Х.Пэрлээ Хүннүгийн үеийн хот сууринг дагнан судалж, дэвсгэр зураг сэлтийг үйлдэн он цагийг тодорхойлсон байдаг. Одоогоор манай улсын нутагт Хүннүгийн үед холбогдох Төв аймгийн Мөнгөнморьт сумын нутаг Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Хүрээн дов,



Борнуур сумын нутаг Бороогийн суурин, Эрдэнэ сумын Өндөр дов, Баянжаргалан сумын нутаг Хэрлэн голын Цагаан арлын Гуа дов, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутагт орших Цэнхэрийн голын хэрэм, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Шувуутайн голын хэрэм, Хутаг Өндөр сумын Эгийн голын сав газар Холтостын хүрэм, Баянгол зэрэг газарт байх Хүннү-Сяньбийн үед холбогдох суурин

газар, Дорнод аймгийн Цагаан овоо сумын Баруун дөрөөгийн хэрэм буюу Барс хот-Ц, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулагийн турь зэрэг хот сууриныг их бага хэмжээгээр судалж он цагийг тогтоогоод байна.

Хүннүгийн хот сууринд ваар савны үйлдвэрлэл ихэд хөгжсөн байсныг Бороогийн суурингийн олдворууд гэрчилдэг.

Хадны зураг. Хүннү нарын үлдээсэн археологийн дурсгалын өөр нэг төрөл бол хадны зураг юм. Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутаг Ямаан усны хавцлын Ханан хаданд дүрслэгдсэн гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг, тамган дүрс, Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутаг Цагаан салаагийн хаднаа буй нохойд хөөгдсөн аргалийг угтан харваж буй анчныг дүрсэлсэн зургууд хүннүгийн үед холбогдоно.



Х а н а н х у р н и й н х э с г э э с , Х о в д , Ү е н ч


ТҮРЭГИЙН ҮЕ

ТҮРЭГИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Түрэгүүд Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм.

Түрэгийн түүхэнд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйл гэвэл, юуны өмнө хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдийг оршуулсан булш зэрэг ордог.

Жирийн иргэдийн онгон. Түрэгийн тайлгын онгон нь хавтан чулууг газарт хайрцаглан суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, түүний өмнө (зүүн талд) байрлуулсан хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ зэрэг үндсэн хэсгээс бүрдэнэ.



Язгууртны онгон. Угсаа сурвалжит язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байдаг. Түрэг улсын төрд онцгой гавьяа байгуулсан цэргийн жанжин, түшмэд, төрийн их хаадын онгоныг шавар хэрэм цогцлон усан шуудуугаар хүрээлж тахилын сүм босгон, шадар бараа бологсод хийгээд зарц үйлчлэгчдийн хөрөг дүрс, арслан, хонь зэрэг амьтны чулуун дүрсүүдийг хийж нүсэр хийц, нарийн зохион байгуулалттай бараа сүр ихтэй том цогцолбор байгууламж босгон хийсэн байдаг. Тахил тайлгын хашлагыг гоёмсог хээ угалзаар чимэглэсэн дөрвөн хавтангаар том хэмжээтэй үйлдэж, булангуудыг нь засмал чулуун бэхэлгээгээр бэхлэх ба зарим тохиолдолд үүний дээрээс голдоо нүхтэй том чулуугаар тагладаг байжээ. Билгэ хаан болон Культегины онгонд энхүү хашлага чулууг голдоо нэвт нүхтэй цул том дөрвөлжин чулуугаар орлуулсан байжээ. Хэрэм дорох хаалганы хатавчинд чулуугаар үйлдсэн арслан буюу хонины дүрсийг хосоор нь үйлдэж өөд өөдөөс нь харуулан тавьсан байдаг. Эдгээрт байх балбал буюу зэл чулууны тоо хэдэн зуу, зарим их томых мянгад ч хүрч байсан бололтой бөгөөд үргэлжлэн цуврах уртын хэмжээ ихдээ 2-3 км хүрдэг байна.

Монгол улсын нутаг дэвсгэрт Архангай аймгийн Хашаат сумын нутаг Хөшөө Цайдам хэмээх газарт буй Билгэ хааны (735) онгон, Культегины (732) онгон, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутагт буй Онгийн голын дурсгал буюу Алп Элтемишийн (731-732) онгон, Төв аймгийн Дэлгэрхаан сумын нутаг дахь Их хөшөөтийн дурсгал буюу Кули-Чурын онгон (742-745), Налайхын орчимд буй Тоньюкук сайдын онгон (720-иод он), Архангай аймгийн Хайрхан, Булганы Баян-Агт сумдын зааг нутагт буй Шивээт Улаан (682-683) зэрэг нарийн зохион байгуулалттай, олон хүн амьтны дүрс бүхий сүрлэг онгонууд бий.



Хө ш ө ө Ц а й Ъ ш м г д а х в а н ы т ё ж м ь т ё н г ю н ы о н д и д ё л ё т а и н ы т ё л ё г л ё ж , и , м ө н г ө т а л т а н а р а л , а л т а н э э м э г

Бичиг үсгийн дурсгал. Түрэгийн соёлын хамгийн гайхамшигт ололт бол Орхон-Енисейн бичиг хэмээн алдаршсан 38 үсэг бүхий авианы бичгийг зохион хэрэглэж, төр улсынхаа түүхийг тэмдэглэн бичиж үлдээсэн явдал билээ.

Манай улсын нутгаас олдсон хамгийн эртний руни бичээс нь Дорноговь аймгийн нутаг Чойроос олдсон хүн чулууны гэдсэн дээрх бичээс юм. Үүнийг 688-691 оны үед бичсэн хэмээн үздэг.

Одоо Монгол нутагт Орхон-Енисейн бичээсээр бичсэн их бага хэмжээний 50 гаруй бичээс илрэн олдож бүртгэгдээд байгаа бөгөөд жил ирэх тутам шинээр нэмэн олдсоор байна. Эдгээрийн дотор Билгэ хааны, Культегин жанжин, Тоньюкукын хөшөө, Онгийн голын хөшөө, Их хөшөөт буюу Кули Чурын хөшөө зэрэг нэр бүхий хаад ноёдын дурсгалд зориулан тусгайлж босгосон хөшөө чулууны бичээсүүд багтана. Түрэгийн



бичгийн дурсгал нь тусгайлж зассан пайлуур гэрэлт хөшөөнөөс гадна байгалийн ердийн хад чулуун дээр, барилгын хананы шааваас дээр, дээврийн ваар дээр, зоос мөнгөн дээр, судар номын баринтагийн тээг чулуун дээр бичсэн зэрэг олон хэлбэрээр олдсоор байна.

Хүн чулуун хөшөө. Монгол нутагт эдүгээ нийт 400 гаруй түрэгийн хүн чулуу илрүүлэн олж бүртгээд байна. Хүн чулуу нь боржин, гантиг, хүрмэн чулуу, элсэн чулуу, занар зэрэг чулуугаар хүний дүр соруулан хийж тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан босгодог хөшөө юм.

Алдар цуутай хаад ноёдын онгоны нүсэр цогцолборын бүрэлдэхүүнд олон хүн чулуу тавьсан байдаг. Тухайлбал, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Өнгөтийн хөшөө хэмээх тахилын том онгоны бүрэлдэхүүнд 28, Культегины онгонд 10, Шивээт Улааны онгонд 9, Их хөшөөтөд 6, Тоньюкукийн болон Билгэ хааны онгон, Өвөрхангай аймгийн Уянга сумын нутаг дахь Онгийн голын дурсгал зэрэгт 5 хүн чулуу мэдэгдэж байна.

Толгой нь бүтэн үлдсэн хүн чулуудыг ажиглахад ихэвчлэн монголжуу өргөн шанаатай, жартгар нүдтэй, нэлээд тохиолдолд махирлаж эргүүлсэн живэр сахалтай байх ажээ. Толгойн үсээ урт ургуулж олон салаа гэзэг, эсвэл ганц бүдүүн гэзэг унжуулах зэрэг байдлаар засч янзалдаг байсан нь түүх сударт тэмдэглэн бичсэнтэй үндсэндээ тохирдог. Энэ бүхнээс үзэхэд түрэгийн хүн чулуу нь тухайн үеийн угсаатны зан заншил, дээл хувцас, эдлэл хэрэглэлийн онцлог, Түрэгийн бүрэлдэхүүнд байсан олон овог аймгийн угсаатны бүрэлдэхүүнийг тодруулан гаргахад нэн ач холбогдолтой дурсгал юм.



Барилга, хот балгад. Түрэгийн үеийн хот суурины дурсгал хэмээн тодорхой нэрлэх дурсгалт зүйлсийг илрүүлэн судалсан нь үгүй боловч тэр үеийн орон барилга, архитектурын хэв маягийг бүрэн харуулж чадах хэрэм далан, тахилын сүм, хөшөө дурсгалын үлдэц уламжлагдан хадгалагдаж иржээ.

Билгэ хаан, Культегин, Тоньюкук, Өнгөтийн хөшөө зэрэг тэр үеийн нэртэй их хаад, цэргийн алдар цуут жанжингуудын дурсгалд зориулсан онгон тайлгын иж бүрэн цогцолбор байгууламжуудыг малтан судлах явцад тоосго, дээврийн тосгуур, нөмрөг, нүүр ваар зэрэг олон тооны барилгын хэрэглэгдэхүүн олддог.



Х а р б ү р а г э н б ү з х и й в а н ө р м р ө

Булш оршуулга. Түрэг булш нь хавтгайдуу дүгрэг чулуун дараастай, 2 м-ээс 10 гаруй м голчтой байх бөгөөд хүний шарилын дэргэд 1-3 адуу дагалдуулж тавьсан байдаг. Хүн, морь

хоёрыг чулуугаар буюу модон гадсаар тусгаарласан байх ба ихэнх тохиолдолд хүн, морины толгой эсрэг чиглэлд хандсан байна. Энэ дурсгалаас зэр зэвсэг, хувцас, гоёл чимэглэл, ахуйн хэрэглээний зүйлс болох сумын зэв, төмөр хутга, нумын ясан наалт, хуягийн ялтас, билүү, ээрүүлийн дунгуй, сав суулгын хэлтэрхий, модон сам, адуу малын тоног хэрэгсэл болох хазаарын амгай зуузай, эмээлийн хэсгүүд, дөрөө, чөдрийн ясан чагт зэрэг зүйлс олддог.

УЙГУРЫН ҮЕ

УЙГУРЫН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Уйгарын археологийн дурсгалуудад хот суурины үлдэгдэл, онгон, хүн чулуу, бичээс, булш оршуулга багтдаг.

Уйгурын хот балгад. Манай улсын нутагт уйгурын үед холбогдох Ордубалык



буюу Харбалгас, Байбалык буюу Бийбулагийн балгас зэрэг томоохон хоёр үлдэгдэл байна.

Харбалгас нь 25 км² талбай эзэлсэн сар том хот байсан нь мэдэгддэг. Хотын талбай нь худалдаа, гар урлалын хэсэг, хааны орд харш, сүм дугана зэрэг хэсгүүдээс бүрдэж байв.

Уйгурын тахил тайлгын онгон. Уйгурын үеийн тахил тайлгын онгоны томоохон төлөөлөл нь Булган аймгийн Сайхан сумын нутаг Могойн шинэ усанд орших Уйгурын хаан Моюн-чурын онгон юм.



Могойн шинэ усны тахилын онгон 25 х 47 м хэмжээтэй гонзгой дөрвөлжин хэрэм, түүний дотуур усан шуудуутай. Төвийн хэсэгт нь дүгрэг хэлбэрээр чулуу овоолж хийсэн голдоо хонхортой чулуун овоолго бий. Дурсгалын хойт хэсэгт, яст мэлхийн нуруунд суурилуулсан урт том хөшөө байсан нь Орхон-Енисейн руни бичээстэй.

Бичиг үсгийн дурсгал. Манай улсын нутагт уйгур нарын үлдээсэн бичиг үсгийн томоохон дурсгалуудад Моюнчурын хөшөөний түрэг бичээс, Тэрхийн




бичээс, Долоодойн бичээст хөшөө, Сүүжийн давааны бичээс, Харбалгасны гурван хэлээр бичсэн их хөшөөний руни бичээс ордог.

Хүн чулуу. Уйгар хүн чулууны онцлог шинж нь, хоёр гараар хэвлийн өмнө сав барьсан, босоо дүрстэйгээс гадна хоёр чихэвчийг нь дээш сөхсөн дүгрэг малгайтай, олон унжлага зүүлт бүхий бүстэй байдаг. Баян-Өлгий аймгийн Сагсай сумын нутаг Битүү, Ногооннуур сумын төвд уйгарын хүн чулуудыг илрүүлэн олжээ.

Булш оршуулга. Уйгарын үеийн булш оршуулгын судалгаа тодорхой хэмжээгээр хийгдсний дүнд Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Дэл уул, Увс аймгийн Цагаанхайрхан сумын нутаг

Цагаанхайрхан уул, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Элс хөтөл, Архангай аймгийн Хайрхан сумын нутаг Баянхар, Архангай аймгийн Хотонт сумын нутаг Олон дов зэрэг газруудаас олж судлагдаад байна.



ХЯТАНЫ ҮЕ

ХЯТАНЫ АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Монгол нутгийн археологийн дурсгал доторх Хятаны түүхэнд холбогдох дурсгалууд нь хот суурины үлдэгдэл, булш оршуулга болно.

Хот суурин. Манай улсын нутагт энэ үеийн хорь орчим хотын үлдэгдэл бий.

Археологич Х. Пэрлээ Хятаны үеийн хот сууриныг хайгуулын журмаар судлан он цагийг урьдчилан тогтоох, зарим хотын үлдэгдлийг их, бага хэмжээгээр малтан судлах зэрэг ажлыг гүйцэтгэж, энэ үеийн хот суурины асуудлыг ихээхэн тодруулжээ.

Монгол улсын нутагт Эмгэнтийн балгас, Талын улаан балгас, Хар бухын балгас, Хадаасангийн балгас, Чин толгой, Дэрсэн хэрэм, Улаан хэрэм, Өглөгчийн хэрэм, Баруун хэрэм, Зүүн хэрэм, Барс хот, Хэрмэн дэрс, Цагаан үзүүрийн балгас, Найдаг уулын дөрвөлжин, Ондгойн дөрвөлжин, Хэрмэн дэнжийн балгас, Цагаан дэнжийн балгас, Талын хэрэм зэрэг хотуудыг илрүүлэн олж судалгааны хүрээнд хамруулаад байна.

Булш оршуулга. Хятан нарын булш оршуулга манай орны нутаг дэвсгэрээс тун цөөхөн олж судлагджээ. Тухайлбал, Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Зүүн бүрэн уул, Хэнтий аймгийн Хэнтий сумын нутаг Хурх, Жаргалантын гол, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутаг Хэрлэнгийн улаан эрэг зэрэг газраас Хятаны он цагт холбогдох булшууд илэрчээ. Эдгээр нь бүгд тоосго, чулуун бунхантай булш юм. Тэдгээрээс тоосго, зээбадын хээтэй нүүр ваар, тосгуур, нөмрөг ваарны үлдэгдлүүд, ширмэн хонх, улаан шавар савны хагархай, зоос, гар тээрмийн бул буюу загасны торны живүүр чулуу, шил, үнэт зүүлтүүд, элдэв төмөр эдлэл, хүрэл товруу, даруулга, яс, шаазан, бог төл малын яс, ширмэн хонх, гуулин цагариг, ёроолдоо нүхтэй том вааран савны хагархай, хээтэй, хээгүй бөөрцөг, амсар зэрэг зүйлс олджээ.





МОНГОЛЫН ҮЕ

МОНГОЛЫН ҮЕИЙН АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛУУД

Монголын эзэнт гүрэн, түүний орыг залгасан Юань гүрэн, бага хаадын үеийн монголчуудын үлдээсэн археологийн дурсгалын тоонд хот суурины үлдэгдэл, булш, хүн чулуу, хадны зураг багтдаг.

Хот суурин. Монголчуудын цогцлоосон хот суурин Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутаг Хархорум хотын туурь, Баянголын амны туурь, Лүн толгойн балгас, Дойтын толгойн балгас, Захын булгийн хэрэм, Мэлхийт толгойн ордны туурь, Талын дөрвөлжин дэх хотын туурь, Хар бондгорын туурь, Улаанбаатар хотын ойролцоох Хар түнийн орд, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутаг дахь Хөгшин тээлийн балгас, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутаг Хар хул хааны балгас, Хөвсгөл аймгийн Эрчүү хотын туурь, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Аваргын балгас, Хэрлэн Барс, Шаазанхот, Халтарын балгас зэрэг олон газарт байдаг.



Хархорум хотын дэвсгэр зураг

Монголчуудын байгуулсан хот суурингаас хамгийн ихээр судлагдсан нь XIII зууны Монголын нэгдсэн улсын нийслэл Хар Хорум хот юм. Хот нь эргэн тойрон хүрээлсэн шавар хэрэмтэй, дөрвөн талдаа хаалгатай, төв хэсэгтээ огтлолцсон хоёр их гудамжаар гар урлал, худалдаа арилжаа, орд харш, сүм хийдийн гэх хэдэн үндсэн хэсэгт хуваагдаж байв.

Монголчуудын барьж байгуулсан хот суурины хамгийн эртнийх болох Аваргын балгас Хэрлэн голын баруун гарын цутгал Аваргын голын хойд эрэгт Рашаан дэрсний ухаа хэмээх уулын өмнө бэлд орших ба 4,5 ам дөрвөлжин км талбай эзлэн оршдог.



Энэ хотыг хүрээлсэн ерөнхий их хэрэм байхгүй боловч дотоод барилгуудыг хүрээлсэн тус тусын хэрэм байх ба худалдаа, гар урлал, шашны сүм хийд, орд харш гэх мэт хэсгүүдтэй, гол орд болон мөргөлийн сүмийг тусгайлан зассан өндөр довжоон дээр байгуулсан байжээ.

Аваргын балгасын гол ордоны чулуун суурь

Монголчуудын булш оршуулга. Дундад зууны монгол булш ихэвчлэн газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн, зууван гонзгой хэлбэртэй, чулуун дараасны



өрлөг нь урт талаараа умар зүг чиглэсэн, цөөвтөр чулуутай, нуугдмал байдалтай байдаг. Дагалдуулан хийсэн зүйлс нь эрэгтэй хүний булшинд байлдааны зэр зэвсгийн зүйлс, тухайлбал, навчин хэлбэртэй нарийн шилбэ бүхий төмөр зэв, нумны ясан наалт, үйсэн саадаг, хоромсого, эмээл, дөрөө, хазаарын хэрэглэл, нэлээд чинээлэг булшинд үнэт төмрөөр хийсэн чимэгтэй бүс, арьс ба торгомсог эдээр хийсэн

хавтага савын зүйл олдох ба эмэгтэй хүний булшинд үйлийн хайч, ээрүүлийн таваг, сам, толь гэх мэт зүйл нийтлэг тохиолдоно. Хүнээ модон авсанд хийж оршуулахын зэрэгцээ авсны оронд үйсээр ороосон байх нь нэлээд таардаг.

Одоогоор манай улсын нутагт дундад зууны монголчуудын булшийг Дорноговь аймгийн төвийн ойр Хар аараг, Алтанширээ сумын ойролцоо, Их Хэт сумын Хөшөөнө ухаа, Дундговь аймгийн төвийн ойрхи Хан уул, Өмнөговь аймгийн Манлай сумын Хар аргалант, Өвөрхангай аймгийн Богд сум, Хархорин сумын Бага Арцат, Маамуу толгой, Эрдэнэзуугийн ойр, Гүмбийн дэнж, Дорнод аймгийн нутаг Чойбалсан хотоос орчим Хэрлэнгийн эрэгт, Хэнтий аймгийн Дадал сумын төвд, Галуут хануул, Мөрөн сумын Чандган тал, Хүйтэн хошуу, Дэлгэрхаан сумын Баян-Улаан уул, Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын Бага Өлзийт, Увс аймгийн Зүүнговь сумын Саран толгой, Сэлэнгэ аймгийн Хонгор сумын Буурал уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Зараа толгой, Хутаг-Өндөр сумын Элст хөтөл, Айдын



хүрэм, Холтост нуга, Баруун Бэлсэгийн ам, Эмгэнт хошуу, Бурхан толгой, Дөрөлж,

Мухдагийн ам, Туул голын хөндий Зүүн Богины ам, Дадарт, Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой зэрэг газруудад малтан судалжээ.

Хадны оршуулга. Монголчууд хүнээ газарт булшлан оршуулахаас гадна сүр бараа ихтэй хад асга бүхий уул хаданд оршуулдаг заншилтай байв. Сүүлийн жилүүдэд ийм хадны оршуулга олноор илэрч олдон судлагдаад байна.

Х ү й т э ж ш у ү х н а ө ө р ш у у 1986 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүйтэн хушууны хаднаас олджээ. Гэрийн ханаар өөд болоочийг ороож тэнэгэр байдлаар тавьсан ба доор нь ясан хяртай модон эмээл хөндлөн тавьсан байжээ. Энэхүү эмээл уужим суудалтай, урд бүүрэг нь босоо өндөр, хойт бүүрэг нь өргөн налуу юм. Мөн төмөр гархи, ээмэг, зэс товч гарчээ. Хамгийн сонирхолтой нэг зүйл бол гавлын ар дагазанд гэзэгний хэсэг хадгалагдан үлдсэн нь хэд салаалан гөрж бөөгнүүлэн мушгиж боогоод хоёр чихний араар унжуулж байсан бололтой байсан бөгөөд энэ нь XIII-XIV зууны үед монгол оронд айлчлан ирсэн харь орны элч жуулчдын замын тэмдэглэлд бичиж үлдээсэн хийгээд мөн үеийн уран зургийн дурсгалд дүрслэн гаргасантай яг адил байжээ.



Ц а г а х а а н н а н а ө ө д и х х а д ю р ш у у Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Цагаан ханангийн агуйгаас модоор угсарч хийсэн хашлагатай, гурван давхар торгоор ороож тавьсан бүрэн хувцастай язгууртан бололтой хүний оршуулга илэрсэн байна. Хэдийгээр тонуулчид анхны байдлыг нь эвдэж тоносон байсан боловч бүтэн үлдсэн эд өлгийн зүйл нь цагаан өнгийн торгоор хийсэн, бөмбөгөр оройтой, ардаа шилэвчтэй, тойрсон дугуй саравч хүрээтэй малгай, сайтар боловсруулсан шар өнгийн ширэн гутал, торгон хэтэвч зэрэг зүйлс байжээ.



Хүн чулуу. Монгол нутгийн уул талаар нэн элбэг тохиолддог дундад зууны үеийн археологийн нэгэн төрөл дурсгал бол чулуугаар хүний дүрс гарган урлаж хийсэн хүн чулуу хэмээх сүрлэг хөшөө юм.

Монгол гүрний үед холбогдох нийт 69 хөрөг бүртгэгдэж судалгаанд хамрагдаад байгаагийн 52 нь Сүхбаатар аймгийн нутагт байна. Түүнчлэн Дорнод (5), Төв (4), Дундговь (2), Өвөрхангай (2), Говь-Алтай (2), Дорноговь (1), Хэнтий (1) зэрэг аймгийн нутгаас илэрч олдсон юм.

Монголчуудын чулуун хөргийн хийц загварын хамгийн нийтлэг онцлог нь баруун гартаа хундага барьж түшлэгтэй сандалд сууж буй хүнийг бүтэн биеэр нь дүрслэх явдал болно. Эдгээр хүн чулуудын дийлэнхийг дээд хувцастай, гоёл чимэглэл болон эд хэрэглэлийн хамтаар урлан хийсэн байхын зэрэгцээ огт хувцасгүй нүцгэнээр дүрсэлсэн хүн чулуу бас тохиолддог. Мөн ихэнх хүн чулууг эр хүний дүрстэйгээр урлан хийхийн хамт эмэгтэй хүний бие бялдар, хувцас эдлэлийн онцлогийг тусган дүрсэлсэн хөшөөд бас бий.

Зарим хүн чулууг онцгой уран нарийн хийцтэйгээр хувцас, гэзэг үс, эд хэрэглэлийг маш уран чадамгай урласан байхад заримынх нь эд зүйлс, хувцас хунарыг тойм төдий дүрслэн гаргасан байдаг нь тэдгээр хүмүүсийн угсаа сурвалж, нийгэмд эзлэх байр суурийг цохон харуулсны шинж бололтой.

Дорнод Монголд буй нийт хүн чулуудын дотор уран нарийн хийц, дүрсэлж гаргасан эд юмс болон бүтэн сайнаараа хадгалагдаж үлдсэн зэрэг байдлаараа онцгой үнэ цэнэтэй нэгэн дурсгал бол Дорнод аймгийн Халх гол сумын Шонх таван толгой хэмээх газраас олдсон чулуун хөрөг юм.



Түүнчилэн Сүхбаатар аймгийн Онгон сумын Таван толгой хэмээх газарт буй хоёр хөрөг нь, хэдийгээр толгой нь хугаран унасан боловч гайхалтай уран нарийн хийц, хүний биеий бодит байдлаар дүрсэлснээрээ нэн онцгой юм.

Монголчуудын хүн чулуун хөрөг нь тухайн үеийн хүмүүсийн бодит дүр төрх, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, эдлэл хэрэглэлийн онцлогийг тусган харуулах түүхэн чухал сурвалж болохын зэрэгцээ тэр үеийн монголчуудын гоо сайхны мэдрэмж, урлаг уран сайхны түвшин, урчууд дархчуудын ур чадварыг илтгэн харуулах дүрслэх урлагийн үнэт дурсгал ажээ.

Бичиг үсгийн дурсгал. Дундад эртний монголчууд нэгдсэн төр улсаа байгуулаад соёлын талаар олсон том дэвшил бол уйгаржин монгол бичгийг төрийн бичиг болгон хэрэглэсэн явдал болно. Улмаар Монголын Их Эзэнт гүрний үед гүрэн даяар нийтээр хэрэглэхэд зориулан дөрвөлжин бичгийг

зохион хэрэглэж байсан уламжлалтай.

Манай нутагт хадгалагдаж үлдсэн эртний судлалын дурсгалууд дотор монгол бичигт пайлуур хөшөө, хад чулуунаа бичсэн дурсгал багагүй байдгийн тоонд Хар Хорумын 1, 2-рмонгол бичээс, Мөнххааны гэрэлт хөшөөний бичээс, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Бичигтийн голын Хадан хушууны бичээс, Дархан-Уул аймгийн Шарын голын Хүйтэн голын бичээс, Их тэнгэрийн амны бичээс зэрэг XIII-XIV зууны үед холбогдох дурсгал, дундад зууны хожуу үед холбогдох Хэсэг байшингийн бичээс, Цогттайжийн Дуутын хар чулууны бичээс зэргийг дурдаж болох юм. Түүнчлэн Монголын дөрвөлжин үсгээр бичсэн зарлиг, зоос, тамга, цаасан мөнгөн тэмдэгт, хад чулуунаа бичсэн зүйлс, пайз болон модон барын ном сударын тасархай зэрэг олон дурсгал хадгалагдан үлдсэн байдаг.

Х а р Х о р у м л а м ж н б о и л ч . Их Монгол улсын нийслэл Хархорум хотноо 1346 онд Тогоонтөмөр хааны зарлигаар босгосон энэхүү гэрэлт хөшөө нь 1380 онд Мин улсын цэрэг Хархорум хотыг довтлох үед эвдэгдсэн гэж үздэг. Хөшөөний бичээс нь Хар Хорум хотын уран барилга, бүтэц зохион байгуулалт, түүнийг сэргээн засварлаж шинээр барилга байгууламж нэмэн барьж байсан талаар өгүүлсэн байдаг. Тухайлбал Хар Хорум хотноо 5 давхар сүм суварга байгуулж, түүнийг хожмын жилүүдэд сэргээн засварлаж сэлбэн барьж байсныг тэмдэглэсэн байдаг нь сонирхолтой.

М ө н х х а г а н р ы э х л ө т и . XIII зууны Их Монгол улсын үед хамаарах бичиг үсгийн нэгэн үнэт дурсгал болох Мөнххааны гэрэлт хөшөө Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутаг Дэлгэрхаан уулын өвөрт, Дэлгэр мөрний зүүн хөвөөнд буй эртний балгасын тууриас олджээ. Хөшөөний нүүрэн талд 3 мөр монгол бичээс, мөн нангиад бичээстэй. Хөшөөний монгол бичээсийг орчин цагийн монгол хэлэнд тоймлон буулгавал: “Ургийн ургаар хэдэн хэдэн үест Мөнххаан түмэн түмэн насалтугай хэмээж Барс Түгэ босгуул...хүртэлана (энэ)-ддавирганд (учралт) буян хүртүгэй” гэжээ.

Хаднызураг. Дундад эртний монголын түүхэнд холбогдох эд өлгийн дурсгал дотор хадны зураг нэгэн төрөл болон ордог билээ. Тухайн үед хад чулуунаа хар бэхээр ямарваа зураг дүрсийг зурж дүрслэн дэргэд нь бичээс үйлдсэн дурсгал, мөн



чулууны толигор гадаргууд нарийн хурц үзүүртэй зүйлээр сараачин зурж хүн амьтан болон байгалийн байдал, орон барилга, эд юмс зэргийг дүрсэлсэн зураг тохиолддог.

И х т э н г э р и м и н н х а д н ы
з у р а Улаанбаатар хотын чанх өмнө, Туул голын өмнө биед Их тэнгэрийн амны зүүн үзүүрийн хойш хандсан хадан хясаанд цаг хугацааны өөр өөр үед холбогдох хадны зургийн гайхамшигт

дурсгал оршдог. Энд хүрлийн үеийн улаан зосон зургаас гадна хар бэхээр зурсан XIII

зууны Их Монгол улсын үед холбогдох зураг, бичээс байдаг онцлогтой. Энэ зургийн хамгийн гол дүрслэл нь нүүрэн талаараа эгц хандсан эмэгтэй хүний бүтэн биеийн дүрс бөгөөд энэ нь урт хормойтой нарийн ханцуйтай дээл, өргөн түрий нарийн хоншоортой гуталтай, энгэртээ давхарлаж хадсан олон гоёл чимэгтэй ажээ. Уг зургийн хамгийн сонирхолтой бөгөөд холбогдох он цагийг тодрохойлох гэрч баримт болсон зүйл нь оройг нь өд мэт зүйлээр чимэглэсэн богтаг малгай болно.

*И х с а р ж а д н ы р Ү*ве аймгийн Сагил сумын нутагт Цагаан голын Үүрэг нуурт цутгах цутгалын урд орших Их сар хэмээн нэрлэгддэг жижиг толгойн баруун тийш харсан нэгэн толигор хаданд матмал махир мөртэй, нуманд навчин хэлбэрийн сум онилсон, нэг хөлөө гишгиж, нөгөө хөлөө өргөн гүйж яваа хүнийг дүрсэлжээ. Энэ хүн одоогийн жанжин малгай маягийн шовх оройтой, дөрвөн талтай, хоёр тийш унжсан чих бүчтэй, духаа дагасан хүрээтэй харагдах малгай, ээтгэр шовх хошуутай гутал өмсч, өргөн бүс бүсэлсэн байх нь эрт үеэс уламжлагдаж ирсэн монгол малгай гуталтай төстэй бөгөөд нумын хэлбэр хийц ч гэсэн XIII зууны үед хэрэглэгдэж байсан монгол нумынхтай ижил байна.